

UCS 1408B:2022

## НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ЭД ХӨРӨНГӨ




Хөшөө, дурсгал, хүндэтгэлийн самбарт  
тавих ерөнхий шаардлага



# НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ЭД ХӨРӨНГӨ

Хөшөө, дурсгал, хүндэтгэлийн самбарт  
тавих ерөнхий шаардлага

*Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2022 оны 23-р тогтоолоор батлав.*



## ГАРЧИГ

1. Хамрах хүрээ .....	5
2. Норматив эшлэл.....	5
3. Нэр томъёоны тодорхойлолт.....	5
4. Төлөвлөлтийн ерөнхий шаардлага .....	6
5. Байршил.....	7
6. Нүүлгэн шилжүүлэх .....	9
7. Тайлбар, нэмэлт мэдээлэл байршуулах.....	10
8. Үзлэг, хяналт, хамгаалалт .....	11
9. Цэвэрлэгээ, засвар үйлчилгээ.....	12
10. Шалгуур үзүүлэлт .....	16
Ашигласан материалын жагсаалт .....	17

### ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Худалдаа үйлчилгээний газрын орчинд .....	8
Зураг 2. Цэцэрлэгт хүрээлэн.....	8
Зураг 3. Төв талбай .....	8
Зураг 4. Гудамж, өргөн чөлөөнд .....	9
Зураг 5. Нүүлгэн шилжүүлэх.....	9
Зураг 6. Хөшөө, дурсгалын нэмэлт мэдээлэл тайлбар.....	10
Зураг 7. Хөшөө, дурсгалт газруудын мэдээлэл .....	10
Зураг 8. Нүүлгэн шилжүүлсэн хөшөө, дурсгалын байршилтай холбогдох мэдээллийг агуулсан самбар.....	11
Зураг 9. Цэвэрлэгээ, засвар үйлчилгээ /өмнөх байдал/ .....	13
Зураг 10. Цэвэрлэгээ, засвар үйлчилгээ /дараах байдал/.....	13

### ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Эд хөрөнгийн үзлэг, хяналтын хуудас.....	11
Хүснэгт 2. Хөшөө, дурсгалын хийц материал бүрт тохирсон цэвэрлэгээ үйлчилгээ .....	14
Хүснэгт 3. Шалгуур үзүүлэлт .....	16



**НИЙСЛЭЛИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2022 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 23

Улаанбаатар хот

┌ Нийтийн эзэмшлийн эд хөрөнгөд ┐  
хамаарах хотын стандартыг батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.15 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалт; Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 дахь хэсэг, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 10<sup>1</sup> дүгээр зүйлийн 10<sup>1.1</sup> дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн иргэдийн эрүүл аюулгүй, амьдрах эрхийг хангахад чиглэсэн Нийтийн эзэмшлийн эд хөрөнгө бүлэгт хамаарах дор дурдсан стандартуудыг хавсралтаар баталсугай. Үүнд:

1.1. UCS1402B:2022 “Нийтийн эзэмшлийн талбайд байгуулах усан оргилуурт тавих ерөнхий шаардлага” хотын стандартыг

1.2. UCS1401B:2022 “Нийтийн бие засах газрын төлөвлөлт байгуулалтад тавих техникийн шаардлага” хотын стандарт

1.3. UCS1403B:2022 “Гадна мэдээллийн байгууламжид тавих ерөнхий шаардлага” хотын стандарт

1.4. UCS 1404B:2022 “Саравч, сүүдрэвчинд тавих ерөнхий шаардлага” хотын стандарт

1.5. UCS1405B:2022 “Хүүхдийн тоглоомын талбайн ерөнхий шаардлага” хотын стандарт

1.6. UCS1406B:2022 “Нийтийн эзэмшлийн зам талбайн хогийн саванд тавих ерөнхий шаардлага” хотын стандарт

1.7. UCS1407B:2022 “Нийтийн эзэмшлийн зам талбайн сандалд тавих ерөнхий шаардлага” хотын стандарт

1.8. UCS1408B:2022 “Хөшөө дурсгал, хүндэтгэлийн самбарт тавих ерөнхий шаардлага” хотын стандарт


1.9. UCS1409B:2022 “Чийрэгжүүлэх талбайн төлөвлөлт, тоног төхөөрөмжид тавих ерөнхий шаардлага” хотын стандарт

1.10. UCS1410B:2022 “Хашаа, хайс, хашлаганд тавих ерөнхий шаардлага” хотын стандарт

1116100320

2.Батлагдсан хотын стандартуудыг мөрдүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д даалгасугай.

3.Энэхүү тогтоолыг 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.

ДАРГА  Ж.БАТБАЯСГАЛАН



Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн .23  
тогтоолын наймдугаар хавсралт

## НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ЭД ХӨРӨНГӨ

### UCS 1408В: 2022 “ХӨШӨӨ, ДУРСГАЛ, ХҮНДЭТГЭЛИЙН САМБАРТ ТАВИХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА” ХОТЫН СТАНДАРТ

#### 1. ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү стандартыг нийтийн эзэмшлийн талбайд хөшөө, дурсгал, хүндэтгэлийн самбар төлөвлөх, байрлуулах үйл ажиллагаанд дагаж мөрдөнө.

#### 2. НОРМАТИВ ЭШЛЭЛ

Энэхүү стандарт нь эш татсан дараах барилгын норм ба дүрэм, стандартын шаардлагыг бүрэн хангах бөгөөд өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлийн эх материалыг үндэслэл болгоно.

- БНБД 30-01-04 – Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм;
- БНБД 32-04-06 – Хот суурины гудамж зам талбайн төлөвлөлт;
- БД 31-112-11 – Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчны шаардлагад нийцсэн зураг төсөл зохиох дүрэм.

#### 3. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

**Дурсгал хүндэтгэлийн самбар** – гэж улс эх орны хөгжилд болон соёл урлагт гавьяа зүтгэл гаргасан зүтгэлтний дурсгалыг мөнхжүүлэх зорилгоор бичсэн дурсгалын үг, бичээс;

**Соёлын биет өв** – гэж түүхэн тодорхой орон зай, цаг үеийг төлөөлөх биетээр оршин байгаа дурсгал;

**Соёлын өв** – гэж түүхэн тодорхой орон зай, цаг үеийн аль нэг хэсгийг төлөөлж чадах байгаль, нийгэм, түүх, соёл, урлаг, шинжлэх ухааны үнэ цэн, ач холбогдол бүхий өв;

**Түүх, соёлын дурсгалт газар** – гэж соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан түүх, соёлын үл хөдлөх дурсгал бүхий газар, түүний хэвлий;

Үүнд: Эртний ургамал, амьтны чулуужсан олдворт газар; эртний хүний оршин сууж байсан ул мөрийг хадгалсан соёлт давхарга; чулуун зэвсгийн олдворт газар; хадны зураг, бичээс; булш, хиргисүүр, оршуулга, тахил, тайлгын байгууламж; эртний хот суурин, сүм хийдийн үлдэгдэл, архитектурын дурсгал; хөшөө, дурсгал; эрт цагт ашигт малтмал олборлож, боловсруулж үйлдвэрлэл, газар тариалан эрхэлж байсан газар,

түүнд холбогдох чулуун дурсгал; тахилгат газар; түүхэн үйл явдал болсон дурсгалт газар;

**Түүх, соёлын үл хөдлөх дурсгал** – гэж унаган газартаа хүрээлэн байгаа орчны хамт үнэ цэн, ач холбогдол нь илэрхийлэгдэх дурсгал;

**Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл** – гэж тодорхой орон зайд шилжүүлэн байрлуулах боломжтой дурсгал;

**Хөшөө** – гэж тухайн улс орон, бүс нутгийн соёл урлаг, түүхэн үйл явдлыг харуулсан, оюун сэтгэлгээний хөгжлийн илэрхийлэл болсон, архитектур, дүрслэх урлагийн шийдэл бүхий байгууламж;

**Хөшөө, дурсгал хүндэтгэлийн самбар, музейн мастер төлөвлөгөө** – гэж хотын нийтийн эзэмшлийн талбай түүний орчимд ирээдүйд бий болох дурсгал хүндэтгэлийн самбарын байршил тогтоох, хөгжүүлэх зорилго бүхий баримт бичиг;

**Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө** – гэж хот, тосгоны хүн амын эрүүл, аюулгүй амьдрах, ажиллах таатай орчныг бүрдүүлэхэд чиглэгдсэн хот байгуулалтын үндсэн баримт бичиг.

#### 4. ТӨЛӨВЛӨЛТИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

4.1. Нийтийн эзэмшлийн талбайд хөшөө, дурсгал хүндэтгэлийн самбар шинээр төлөвлөх, шилжүүлэх үйл ажиллагаанд дараах шаардлага тавина. Үүнд:

4.1.1. хөшөө, дурсгалыг төлөвлөн байгуулахдаа холбогдох байгууллагуудын зөвшөөрөл буюу зөвшилцсөн албан бичиг, орчны тохижилтын төлөвлөлт, батлагдсан зураг төслийн дагуу гүйцэтгэнэ;

4.1.2. хөшөө, дурсгал хүндэтгэлийн самбарын эх загварыг өөрчлөхгүй, батлагдсан зургийн дагуу босгох асуудлыг орон нутгийн захиргааны байгууллага болон захиалагч хариуцна.

4.2. Хөшөө, дурсгал, хүндэтгэлийн самбарын ашиглалтын үед гадаад орчны нөлөөлөл үйлчлэлийн дараах зүйлсийг анхаарах шаардлагатай. Үүнд:

4.2.1. хөшөө, дурсгалын орчинд байрлах мод, бут нь шувууг татаж шувууны ялгадас, болон модноос ялгарах шүүс, байгалийн давирхай, тос нь хөшөөг бохирдуулдаг. Модны навч, үр нь ан цавд байрлаж, чийгийг хадгалж, зэврэлт болон бусад эвдрэлд хүргэдэг;

4.2.2. хөшөө, дурсгалыг сүүдэрлэсэн байршилд байрлуулах нь замаг болон бусад биологийн өсөлтийг дэмжих нөхцөл болдог. Мөн сүүдэр нь баримлыг жигд бус хатаахад хүргэнэ;

4.2.3. хөшөө, дурсгалын орчны ногоон байгууламжийн усалгааг хийхдээ хөшөөнд ус цацагдахаас зайлсхийхийн тулд услах арга технологийг зөв төлөвлөх хэрэгтэй;

4.2.4. барилга байгууламж болон авто замын засвар, арчлалтын ажил түүний зэргэлдээ орших хөшөө, дурсгал, уран барималд нөлөөлж болдог. жишээлбэл, ойролцоох барилгыг дахин будах явцад будаг цацагдах тохиолдол гардаг. зам, замын хажуугийн баримлууд нь мөс хайлуулах давс цацах үед давсан бүрхүүл үүсэж эвдрэх нөхцөл бүрддэг;



- 4.2.5. ус нь хөшөө, дурсгалын дизайны элемент байх тохиолдолд хөшөө, дурсгалын уснаас хамгаалах бүрхүүлийг дахин хийх засвар, үйлчилгээний нэмэлт хэрэгцээ бий болох тул урьдчилан тооцоолох шаардлагатай;
- 4.2.6. өвлийн улиралд хөлдөлт нь хөшөө, дурсгалд ихээхэн хохирол учруулдаг тул хөшөө, дурсгалын ус хадгалах бүх элементийг бүрэн хатаах шаардлагатай байдаг;
- 4.2.7. дамжуулах хоолой, насос болон бусад цахилгаан ба механик эд ангиуд нь хүрэл, гууль, зэвэрдэггүй ган зэрэг материалаар хийгдсэн байх ёстой;
- 4.2.8. усны хүчил, суурь бодис, биологийн угаалгын нунтаг нь хөшөө, дурсгалыг хийсэн материалд нөлөөлж болох тул усан оргилуурын усны химийн найрлагыг сайтар хянаж байх шаардлагатай.

## 5. БАЙРШИЛ<sup>1</sup>

- 5.1. Дурсгал хүндэтгэлийн самбарыг төр, нийгмийн зүтгэлтэн болон гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэх зорилгоор түүний ажиллаж байсан албан байгууллага болон амьдарч байсан байрны хананд байрлуулна.
  - 5.1.1. Дурсгал хүндэтгэлийн самбарын хэмжээг байрлуулах гэж буй барилгын хана, фасадын өнгө, тухайн орчны орон зайн хэмжээ, харагдах нөхцөлөөс хамааран төлөвлөнө;
  - 5.1.2. Хөшөө, дурсгал, хүндэтгэлийн самбар дээр байрлуулах үг нь Монгол хэлээр болон шаардлагатай гэж үзвэл англи хэлээр давхар бичиж болох ба уншихад ойлгомжтой, үг үсэг, утга найруулгын хувьд алдаагүй байна.
- 5.2. Шинээр байгуулах болон нүүлгэн шилжүүлэх хөшөө, дурсгал хүндэтгэлийн самбарын байршил тогтооход дараах зүйлсийг харгалзан үзэх шаардлагатай. Үүнд:
  - 5.2.1. тухайн хөшөө, дурсгалын загвар, дизайн, утга санаа, өгүүлэмжийг илэрхийлэхэд хүрэлцээтэй орон зайд төлөвлөнө;
  - 5.2.2. түүх, соёлын ач холбогдолтой байршилд байх;
  - 5.2.3. орчны тохижилтын элементүүдтэй уялдуулах;
  - 5.2.4. инженерийн шугам сүлжээний хамгаалалтын зурваст байрлуулахгүй байх;
  - 5.2.5. хөшөө, дурсгал байрлуулах боломжтой эсэх талаар эрх бүхий байгууллагын зөвшөөрөл.

<sup>1</sup> Олон улсын туршлагаас үзвэл хөшөө, дурсгал хүндэтгэлийн самбарыг спортын байгууламж, цэнгэлдэх хүрээлэн, төрийн байгууллагын барилга байгууламж, хотын төв талбай, худалдаа үйлчилгээний төв, цэцэрлэгт хүрээлэн, музейд голчлон байрлуулдаг.



Зураг 1. Худалдаа үйлчилгээний газрын орчинд (Жишээ зураг)



Зураг 2. Цэцэрлэгт хүрээлэн (Жишээ зураг)



Зураг 3. Төв талбай (Жишээ зураг)



Зураг 4. Гудамж, өргөн чөлөөнд (Жишээ зураг)

## 6. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ

- 6.1. Хөшөө, дурсгал, хүндэтгэлийн самбар нь байрлаж байгаа газартайгаа уялдаа холбоогүй, урьд нь өөр газраас шилжин ирсэн, эсхүл хүрээлэн буй орчин нь өөрчлөгдсөн тохиолдолд нүүлгэн шилжүүлнэ.
- 6.2. Хөшөө, дурсгал, хүндэтгэлийн самбарыг нүүлгэн шилжүүлэхдээ холбогдох эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг үндэслэн хадгалалт, хамгаалалтыг өндөр түвшинд, эвдэлж гэмтээхээс сэргийлэн, хөдөлмөрийн аюулгүй байдлыг бүрэн хангасны дараа гүйцэтгэнэ.




Зураг 5. Нүүлгэн шилжүүлэх (Жишээ зураг)



Зураг 6. Хөшөө, дурсгалын нэмэлт мэдээлэл тайлбар (Жишээ зураг)


## 7. ТАЙЛБАР, НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ БАЙРШУУЛАХ

- 7.1. Хөшөө, дурсгалын түүх, соёлын ач холбогдлын талаар мэдээлэл агуулсан самбарыг хөшөө дурсгалын дэргэж байрлуулна.
- 7.2. Хөшөө, дурсгал хүндэтгэлийн самбарын мэдээллийг агуулсан бичвэрийг тохиромжтой материалаар хийж, удаан эдэлгээтэй байлгах, болзошгүй эвдрэлээс урьдчилан сэргийлэх шаардлагатай.



Зураг 7. Хөшөө, дурсгалт газруудын мэдээлэл (Жишээ зураг)

- 7.3. Хөшөө, дурсгалыг байрлалаас нь шилжүүлсэн болон буулгасан тохиолдолд тухайн байршил дахь хөшөө, дурсгалын байршилтай, холбогдох мэдээллийг агуулсан самбар байрлуулна.



*Зураг 8. Нүүлгэн шилжүүлсэн хөшөө, дурсгалын байршилтай холбогдох мэдээллийг агуулсан самбар (Жишээ зураг)*

## **8. ҮЗЛЭГ, ХЯНАЛТ, ХАМГААЛАЛТ**

- 8.1. Хөшөө, дурсгалын аюулгүй байдал хадгалалт хамгаалалтыг хангах зорилгоор Нийслэлийн соёл урлагийн газар хөшөө, дурсгалыг эзэмшигч иргэн аж ахуйн нэгж байгууллагатай гэрээ байгуулна.
- 8.2. Хөшөө, дурсгалын хэвийн байдлыг хангахын тулд тогтмол баримтжуулсан хяналт шалгалт хийх шаардлагатай бөгөөд арчлалт засвар үйлчилгээнд нэмэлт нарийн арга технологи шаардагдах эсэхийг тодорхойлно. Үзлэг, хяналт хийх асуумжийг Хүснэгт 1-д үзүүлэв.
- 8.3. Үзлэг, хяналт хийх үйл ажиллагааны үед тухайн хөшөө, дурсгалд хийсэн бүх арга хэмжээ, ашигласан материал, гүйцэтгэсэн ажил, цаашид хийх засвар үйлчилгээний талаар баримтжуулж, аливаа гүйцэтгэсэн ажлыг үнэлж, алдаа оноогоо дүгнэж баталгаажуулна.
- 8.4. Хөшөө, дурсгалыг ашиглах үйл ажиллагаанд үзлэг, хяналт хийх, хамгаалах, цэвэрлэх, засварлах, баримтжуулах үйл ажиллагааг цогцоор ойлгох бөгөөд хариуцагч байгууллага иж бүрэн төлөвлөгөө боловсруулж гүйцэтгэнэ.

## Хүснэгт 1. Эд хөрөнгийн үзлэг, хяналтын хуудас

№	Хяналт үнэлгээ хийх чиглэл	Тийм	Үгүй
1	Хөшөө, дурсгалыг зөв байршуулсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2	Хөшөө, дурсгалыг үйлдвэрлэгчийн заавар, стандартын шаардлагын дагуу суурилуулсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3	Хөшөө, дурсгалд эд хөрөнгөд механик гэмтэл удирсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4	Бохирдолтой эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5	Бэхэлгээ, эд анги, элэгдсэн, суларсан, гэмтсэн, мултарсан, гээгдсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
6	Эд хөрөнгөд өгөршил, илжрэл, ялзрал явагдсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
7	Эвдэн сүйтгэх үйл ажиллагаанд өртсөн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

**Тайлбар:** Хөшөө, дурсгал нь дээрх бүх шаардлагыг хангаж байх ёстой бөгөөд шаардлага хангасан бол “Тийм” хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол “Үгүй” хэсгийг тэмдэглэнэ.

Хөшөө, дурсгалд учирсан зөрчлийн талаар мэдээлэхдээ “Зөрчил мэдээлэх хуудас”-ийг боловсруулж ашиглана. Зөрчил мэдээлэх хуудсанд дараах мэдээлэл, асуумж заавал агуулагдсан байх ёстой. Үүнд:

- эд хөрөнгийн нэр;
- эд хөрөнгийн хохирол, талбайн байршил зураг;
- хохирол гарсан цаг хугацаа, огноо;
- хэрэг явдал болсон газар, дүүрэг, гудамжны нэр;
- үйл явдлын видео тандалтын бичлэг;
- үйл явдлын товч тодорхойлолт;
- гэрч, оролцогч талуудын нэр, холбоо барих хаяг.

## 9. ЦЭВЭРЛЭГЭЭ, ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ


9.1. Хөшөө дурсгалын бүрэн бүтэн, өнгө үзэмжтэй байдлыг хангах зорилгоор засвар, үйлчилгээ цэвэрлэгээг тогтмол хийнэ. Хөшөө, дурсгалд засвар, үйлчилгээ хийхдээ бүтээгчийн өгсөн зөвлөмж, тогтоосон стандарт, техникийн зааварчилгааг баримтлах бөгөөд технологийн карт, аюулгүй ажиллагааны дүрэм боловсруулж мөрдөн ажиллана.

9.2. Засвар, үйлчилгээ үзүүлэх байгууллага нь үйлчилгээ, засварын ажилдаа замын хөдөлгөөн, хөдөлмөрийн аюулгүй байдлын шаардлагад нийцэж байгаад баталгаа гаргаж өгөх ба баталгааг баримтжуулна.

9.3. Зохиогч нь тухайн хөшөө, дурсгалын арчлалт засвар үйлчилгээний техникийн шаардлагыг боловсруулан баталгаажуулах, бусад шаардлагатай мэдээллийг багтаасан хуудсыг хүлээлгэн өгнө. Үүнд:

- засвар үйлчилгээнд хэрэглэгдэх материалын жагсаалт;
- засвар үйлчилгээ хийх технологи;
- хадгалах, тээвэрлэх нөхцөл;
- байгуулалтын зураг төсөл.

### ЦЭВЭРЛЭГЭЭ, ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ ХИЙХЭЭС ӨМНӨ



Зураг 9. Цэвэрлэгээ, засвар үйлчилгээ /өмнөх байдал/ (Жишээ зураг)




### ЦЭВЭРЛЭГЭЭ ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ ХИЙСНИЙ ДАРАА





Зураг 10. Цэвэрлэгээ засвар үйлчилгээ /дараах байдал/ (Жишээ зураг)

- 9.4. Хөшөө, дурсгалын цэвэрлэгээ хамгийн энгийн бөгөөд хялбар арга бол усалгааны хоолой ашиглан усаар шүршиж цэвэрлэх.
- 9.5. Төмөр, ган, шавар, чулуу, бетон хийц материалтай баримлуудыг жилд нэгээс доошгүй удаа усаар шүршиж цэвэрлэнэ.
- 9.6. Хүрэл баримлуудыг тунгалаг, үнэргүй угаалгын бодисоор жилд нэгээс доошгүй удаа цэвэрлэвэл зохистой. Хөшөө, дурсгалын хийц материал бүрт тохирсон цэвэрлэгээ үйлчилгээний талаар Герман улсад хэрэглэгдэж буй заавар, мэдээллийг доорх хүснэгтэд харуулав.

*Хүснэгт 2. Хөшөө, дурсгалын хийц материал бүрт тохирсон цэвэрлэгээ үйлчилгээ*

 <p>Хөнгөн цагаан хийц материалын хөшөө, дурсгал (Жишээ зураг)</p>	<p>Хөнгөн цагаан материал нь гадаад орчинд цагаан эсхүл цайвар саарал зэврэлтийг үүсгэдэг бөгөөд энэ нь ихэвчлэн нимгэн нунтаг хальст байдаг. Үүнийг хөндөхгүй үлдээх хэрэгтэй. Бохирдлыг цэвэрлэхдээ усалгааны хоолойг ашиглан усаар хүчтэй шүршиж угаана.</p> <p>Цэвэрлэх давтамж: Сар бүр угаавал зохимжтой.</p> <p>Анхаарах зүйлс:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Цэвэрлэх явцад хөнгөн цагааны өнгө өөрчлөгдөж, гялалзаж эхэлбэл зогсоох хэрэгтэй;</li> <li>• Автомат даралтат угаагчаар угаахгүй байх;</li> <li>• Энгийн хөнгөн цагаан цэвэрлэгч хэрэглэхгүй;</li> <li>• Ацетон ба метил этил кетоны төрлийн уусгагчаар угаах.</li> </ul>
 <p>Өгөршсөн ган хийц материалын хөшөө, дурсгал (Жишээ зураг)</p>	<p>Бохирдлыг цэвэрлэхдээ усалгааны хоолойг ашиглан усаар сайтар шүршиж угаана.</p> <p>Цэвэрлэх давтамж: Сар бүр цэвэрлэх нь тус төрлийн материалтай хөшөө, дурсгалд тохиромжгүй юм. Тиймээс жилд доод тал нь 1 удаа угаавал зохистой.</p> <p>Анхаарах зүйлс:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Сүлжмэл даавуу ашиглах;</li> <li>• Гүн зэврэлтийг арилгахдаа хүчиллэг бус шүлтлэг төрлийн бодис сонгох;</li> <li>• Гангийн гүн зэврэлтийг сойздож үрж угаахгүй байх;</li> </ul> <p>Автомат даралтат угаагчаар угаахгүй байх.</p>
 <p>Өнгөт ба будагтай метал хийц материалын хөшөө, дурсгал (Жишээ зураг)</p>	<p>Бохирдлыг цэвэрлэхдээ усалгааны хоолой ашиглан усаар шүршиж угаана.</p> <p>Цэвэрлэх давтамж: Сар бүр цэвэрлэх нь тус төрлийн материалтай хөшөө, дурсгалд тохиромжгүй юм. Иймд жилд доод тал нь 1 удаа угаавал зохистой.</p> <p>Анхаарах зүйлс:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Энгийн угаагч бодис нь ихэвчлэн будгийн өнгийг бүдгэрүүлэх тул техникийн зориулалттай спирт, нафта ашиглан гүн бүхирдлыг арилгах нь зохистой;</li> <li>• Будаг нь хууларсан ховхорсон тохиолдолд хөшөөний дотоод хийц материалд засвар, үйлчилгээ хийж сайтар хатсаны дараа шинэчлэн будах.</li> </ul>



 <p>Хүрэл болон зэс хийц материалын хөшөө, дурсгал (Жишээ зураг)</p>	<p>Хүрэл болон зэс хийц материалтай хөшөө, дурсгалын хувьд гадаргуугийн бүрхүүлээс хамаарч өөр өөр төрлийн цэвэрлэгээ үйлчилгээ хийгддэг. Хөнгөн цэвэрлэгээг боломжтой бол 7 хоног бүр усаар шүршиж хийх хэрэгтэй.</p> <p>Хөнгөн цэвэрлэгээний дараа лавдаж өнгөлгөө хийж засварлана.</p> <p>Лавдаж өнгөлгөө хийх ажлыг жилд 1 удаа хийсэн байх шаардлагатай.</p> <p>Анхаарах зүйлс:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Хүрэл баримлыг тунгалаг, үнэргүй аяга таваг угаагч бодис ашиглан угааж болно;</li> <li>• Дулаан, нарлаг өдөр лав түрхэж өнгөлгөө хийх;</li> <li>• Лавны өнгөлгөөг хийхдээ гутлын сойтог эсхүл хөвөн даавуун материал ашиглан үрвэл зохистой.</li> </ul>
 <p>Чулуун, Шавар, Шилэн хийц материалын хөшөө, дурсгал (Жишээ зураг)</p>	<p>Тус төрлийн хөшөө, дурсгал нь голчлон хөлдөлт, гэсэлтийн, цохилтын эвдрэл, гэмтлээс болж гэмтдэг. Цэвэрлэгээ хийхдээ зөөлөн сойз, цэвэр, үнэргүй угаалгын нунтаг ашиглан шүршиж давтан зайлалтыг 2-3 удаа давтаж хийнэ.</p> <p>Анхаарах зүйлс:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Нэрмэл буюу ионгүйжүүлсэн ус хэрэглэхээс зайлсхийх;</li> <li>• Автомат даралтат угаагчаар угаахгүй байх;</li> <li>• Давтан хэд хэдэн удаа зайлах.</li> </ul>
 <p>Модон хийц материалын хөшөө, дурсгал (Жишээ зураг)</p>	<p>Цэвэрлэх давтамж: жилд нэг удаа цэвэрлэх хэрэгтэй.</p> <p>Анхаарах зүйлс:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Сойз шүүр ашиглан цэвэрлэх;</li> <li>• Ус, эсхүл уусгагчаар угааж болохгүй;</li> <li>• Гүн толбыг арилгахад хэцүү тул мэргэжлийн хүмүүсээс зөвөлгөө авах.</li> </ul>

*Жич: Ус ашиглан хийгдэх цэвэрлэгээг дулааны улиралд хийх нь тохиромжтой.*

## 10. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Нийтийн эзэмшлийн талбайд хөшөө, дурсгал хүндэтгэлийн самбарыг шинээр төлөвлөх, шилжүүлэн нүүлгэх, хөшөө, дурсгалд учирсан эвдрэл, гэмтлийг хүснэгт 3-ын дагуу хянан шалгана.

*Хүснэгт 3. Шалгуур үзүүлэлт*

№	Шалгуур үзүүлэлт	Тийм	Үгүй
1	Барилгын ажлын зураг төсөлтэй байх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2	Авто замын төлөвлөлттэй уялдсан байх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3	Явган хүний зам, талбай, хөдөлгөөний чиглэлийг анхаарч тусгасан байх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4	Инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийн хангамж, техникийн нөхцөлтэй байх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5	Тухайн орчинд байрлуулах нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн байрлал, тоо, дизайныг тусгасан байх /сандал, хогийн сав, мэдээллийн байгууламж гэх мэт/	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
8	Цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламж төлөвлөгдсөн байх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
9	Засвар үйлчилгээний техникийн шаардлагатай эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
10	Гэрэлтүүлэг гэрлэн чимэглэлтэй байх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
11	Тогтмол хяналт хийх, гэмт үйлдлээс хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй байх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
12	Арчилгаа, цэвэрлэгээ, засвар үйлчилгээний төлөвлөгөөтэй байх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

**Тайлбар:** Хөшөө, дурсгал нь дээрх бүх шаардлагыг хангаж байх ёстой бөгөөд шаардлага хангасан бол **“Тийм”** хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол **“Үгүй”** хэсгийг тэмдэглэнэ.

## **АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ**

- Улсын нийслэлд хөшөө, дурсгал хүндэтгэлийн самбар байрлуулах журам. 2010. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 55 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт
- Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах хөтөлбөр /Засгийн газрын 2007 оны 303 дугаар тогтоолын хавсралт/
- Соёлын өвийг хамгаалах тухай Монгол улсын хууль
- Guidelines for public monuments and memorials. Adapted from the “Public Monuments and Memorials Project by SAHRA for DAC” (2003) and amended following the public consultation meeting held at Freedom Park on 17 April 2015 on the Transformation of the Heritage Landscape in South Africa
- Memorials and museums master plan of Washington. December 2001. National Capital Planning Commission
- National Heritage Resources Act of South Africa. 1999. System for management of national heritage resources. No. 25
- "Maintenance of outdoor sculpture manual 2017" Герман улсын хөшөө, дурсгалын засвар үйлчилгээний гарын авлага



Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг  
ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗАР



Хан-Уул дүүрэг, 23-р хороо, 17100, Наадамчдын зам  
1200, Нутгийн захиргааны цогцолбор байр.



70118030, 70118040



[www.standard.ub.gov.mn](http://www.standard.ub.gov.mn)



Хотын стандарт, хяналтын газар